

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын сар тутмын сонин 2017 оны 9 сарын дугаар

Тэргүүн мэдээ.

ЖАЙКА-ийн Сайн дурын хамтын ажиллагааны 25 жилийн ойн ёслолын арга хэмжээ болов.



Ёслолын ажиллагааны үеэр илтгэл тавьж буй анхны сайн дурын гишүүн

Монгол улс дахь ЖАЙКА-ийн сайн дурын хамтын ажиллагааны 25 жилийн ойд зориулсан ёслолын арга хэмжээ 9 сарын 29-ний өдөр боллоо. 1992 оны 4 сард анхны 2 залуу сайн дурын гишүүн томилогдон ирснээр Монгол дахь ЖАЙКА-ийн сайн дурын хамтын ажиллагаа эхэлсэн бөгөөд өнөө хүртэл нийт 650 сайн дурын гишүүн боловсрол, эрүүл мэнд, спорт зэрэг олон салбарт амжилттай ажиллаж ирсэн байна. Ёслолын арга хэмжээнд Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Япон улсын Элчин сайд Такаока нарын хүндэт зочдоос гадна сайн дурын гишүүд, тэднийг хүлээн авсан байгууллагын төлөөлөл зэрэг 200 гаруй хүн оролцлоо. Ёслолын арга хэмжээний үеэр 25 жилийн түүхийг хүүрнэсэн богино хэмжээний кино үзүүлж, үе үеийн сайн дурынхан үйл ажиллагаагаа танилцуулсан бол хэлэлцүүлгийн үеэр 25 жилийн түүхэн замнал ба ололт амжилтыг эргэн харж, хоёр орны хоорондын өвсний үндэс хөтөлбөрийн түвшний хамтын ажиллагаа болох сайн дурын гишүүн илгээх хамтын ажиллагаа нь Монгол улсын хөгжилд хувь нэмэр оруулж ирсэнийг тодотгов. ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд цаашид ч цаг үе ба нийгмийн өөрчлөлтөд уян хатан зохицож, монголчуудтай хамт шинэ зам гаргаж явах болно.

Дурсгалын богино кино: “ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг илгээж эхэлсэний 25 жилийн ой: Гэрэлт ирээдүйн төлөө хамтдаа!” → [Энд дарах](#)

Улс төр, эдийн засгийн чиг хандлагын тойм

Ж.Эрдэнбатын засгийн газар бүрэн бүрэлдхүүнээрээ огцорч, шинэ засгийн газар байгуулагдахаар болов.

2017 оны 9 сарын 7-ны өдөр хуралдсан УИХ-ын ээлжит бус чуулганы хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналын талаар хэлэлцэж, “Засгийн газрыг огцруулах тухай” УИХ-ын тогтоолыг баталсанаар, 2016 оны 7 сард байгуулагдсан Ерөнхий сайд Ж.Эрдэнбатын Засгийн газар 1 жил гаруй хугацааны дараа бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох болсон. 2017 оны 7 сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд эрх баригч МАН-аас нэр дэвшигч УИХ-ын дарга М.Энхболд ялагдсаны дараа Ж.Эрдэнбатын Засгийн газрыг эсэргүүцэгч МАН-ын зарим гишүүд сонгуульд ялагдсаны хариуцлага тооцох, авилгын хэргүүдийг шалгахыг шаардах, Засгийн газарт итгэл үзүүлэхээс татгалзах зэргээр МАН-ын дотоод дахь фракц хоорондын зөрчил үргэлжилсээр байна. Засгийн газрын тухай хуулиар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг 30 хоногийн дотор Ерөнхийлөгчтэй зөвшилцөн УИХ-д өргөн мэдүүлж томилох ёстой бөгөөд 10 сарын 2-нд эхлэх УИХ-ын намрын чуулганы эхэнд Ерөнхий сайдыг томилох төлөвтэй байна.

Улсын сургуулийн багш нар цалин нэмэхийг шаардан ажил хаяв.

9 сарын 21, 26-нд Улаанбаатар хот болон орон нутгийн зарим сургууль, цэцэрлэгийн багш нар ажил хаялт зарлав. Улсын сургуулийн “Багш нарын цалин нэмэгдүүлэх түр хороо” Засгийн газарт хандан цалин нэмэх шаардлага тавьсан боловч Засгийн газрын зүгээс хариу өгөөгүй тул ажил хаялт зарласан байна. Багш нарын цалин нэмэх шаардлагыг Засгийн газар биелүүлэхгүй бол хугацаагүй ажил хаялт зарлахаа мэдэгдсэн бөгөөд Засгийн газрын зүгээс ямар арга хэмжээ авах нь анхаарал татаж байна.

Төслийн хэрэгжилтийн тойм

“Улаанбаатар хотын нийтийн тээврийн дизель хөдөлгүүртэй шугамын автобусанд хорт утаа шүүгч (DPF) суурилуулан, хөө тортогийн ялгарлыг бууруулах туршилтын төсөл” –ийн санамж бичигт гарын үсэг зурав.



Гарын үсэг зурах ёслол

9 сарын 22-нд Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат байлцан тус яам, НЗДТГ, ЖАЙКА-ийн хооронд “Улаанбаатар хотын нийтийн тээврийн дизель хөдөлгүүртэй шугамын автобусанд хорт утаа шүүгч (DPF) суурилуулан, хөө тортогийн ялгарлыг бууруулах туршилтын төсөл”-ийн санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү төслийн хүрээнд Японы Комотек компаний үйлдвэрлэсэн хорт утаа шүүгчийг (DPF) Улаанбаатар хотын төвийн шугамын автобусанд тавих, ашиглалтын тогтолцоог нэвтрүүлэх, туршилтын төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудыг судлах юм. Тус компаний хорт утаа шүүгч нь (DPF) төслийн урьдчилсан судалгаагаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад үр нөлөөтэй болох нь тогтоогдсон бөгөөд монголд бизнесийн үйл ажиллагаа эрхлэн агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулна гэж найдаж байна.


Өвсний үндэс ТХА “Тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эргэлтийг эрчимжүүлэх, хөрс сайжруулах төсөл”-ийн шууд борлуулах цэг нээгдлээ!



Нээлтийн ёслол

9 сарын 12-нд 2016 оны 3 сараас хэрэгжүүлж буй өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа “Тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эргэлтийг эрчимжүүлэх, хөрс сайжруулах төсөл”-ийн хүрээнд барьсан ХАА-н бүтээгдэхүүний шууд борлуулалтын цэг нээгдлээ. Төслийн санаачлагч нь Японы Хоккайдо мужийн Обихиро хот бол хэрэгжүүлэгч байгууллага нь Хоккайдо мужийн Жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооны Токачи салбар бөгөөд тус төслөөр ХАА-н бүтээгдэхүүний чанарыг сайжруулан шууд борлуулах цэгээс борлуулснаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэхийг зорьж байна. Энэхүү шууд борлуулах цэг нь Улаанбаатар хотоос 90 км-ийн зайтай буюу Дархан-Уул аймаг орох төв замын дагуу Аглагийн хийд явах уулзвар дээр байрлах тул боломжтой үедээ заавал буугаад мордоорой. Цаашид хөрс сайжруулах технологи нэвтрүүлэхийн хамт шууд борлуулах цэгийн менежмент, хүнс боловсруулах технологи, нутгийн бренд бий болгох арга хэмжээ зэргийг нэвтрүүлэн тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх зорилт тавьж байна.


“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төслийн 3-р шатны ” нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгааг хэрэгжүүлэв.



Төсөл хэрэгжүүлэгчид гар барьж байгаа нь.

8 сарын 30-наас 9 сарын 13-нд техникийн хамтын ажиллагааны “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төслийн 3-р шат” -ны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгааг хэрэгжүүлэн, Улаанбаатар хотын Агаарын бохирдлыг бууруулах газар болон БОАЖЯ-тай төслийн ерөнхий агуулгын талаар тохиролцов. Энэ нь уг төслийн төгсгөлийн үе шат болох бөгөөд агаарын бохирдлын хяналтын үр нөлөөтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх болон ялангуяа улс ба нийслэлийн хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Тэрчлэн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний салбарт АХБ болон Дэлхийн банк идэвхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2018 оны эхээр уг төслийг хэрэгжүүлж эхлэхээр бусад донорууд болон монголын талын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа уялдуулахаар төлөвлөж байна.

“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн үндсэн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил явагдав.



Гарын үсэг зурах ёслол

8 сарын 9-ний өдрөөс 9 сарын 15 өдөр хүртэл техникийн хамтын ажиллагааны “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн үндсэн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил явагдав. ЖАЙКА энэхүү судалгаанаас өмнө 2016 оны 10 сараас 2017 оны 2 сар хүртэл “Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрөнгө оруулалтын салбарын суурь судалгаа” хийж, холбогдох мэдээлэл, асуудлуудыг цэгцлэн шинжилж, Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газартай уг төслийг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр ярилцаж ирсэн юм. Энэхүү судалгаагаар төслийн хамрах хүрээ, агуулга, хэрэгжүүлэх тогтолцоо, бусад хандивлагчидтай үйл ажиллагаагаа уялдуулах зэрэг асуудлыг тодруулахын хамт төсвийн алдагдал ба өрийг нэмэгдүүлэхгүй байдлаар хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийн ач холбогдолыг тодотгов. Цаашид 2018 оны 1 сараас энэхүү төслийг хэрэгжүүлж эхлэх чиглэлээр бэлтгэл ажлыг хангаж байна.

“Улаанбаатар хотод ЕБС-ын барилга барих төслийн” бэлтгэл судалгаа хэрэгжиж дуусав.



Бэлтгэл судалгааны санамж бичигт гарын үсэг зурах ёслол

ЖАЙКА 1999 оноос хойш монгол улсад сургуулийн барилга барих, өргөтгөх дөрвөн шатны төсөл хэрэгжүүлэн нийт 40 мянган хүүхэд суралцах сургуулийн барилга байгууламж барьсан байдаг. Гэвч нийслэл хотын хүн ам хурдацтай өсч буй улмаас харьяаллын бус сургуульд суралцах, олон ээлжээр хичээллэх асуудал болон сургуулийн барилга олон шаардлага хангасан байх шаардлагатай болж буй зэрэг шийдэгдээгүй асуудал байсаар байна. Ийм нөхцөл байдалд үндэслэн буцалтгүй тусламжаар “Улаанбаатар хотод ЕБС барих төсөл”-ийн бэлтгэл судалгааг хэрэгжүүлэв. Энэхүү судалгааны явцад өнөөгийн боловсролын барилга байгууламжид тулгарч буй асуудлууд, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, гамшгийн үед сургуулийн барилгыг түр хоргодох байрны зориулалтаар ашиглах боломж хязгаарлагдмал байгааг тодруулав. Цаашид эдгээр асуудлыг шийдвэрлэх арга замыг тусгасан сургуулийн барилга барих шаардлага тавигдаж байгаа юм. Энэхүү төслийн хүрээнд дээрх хэрэгцээ шаардлагыг хангах “Загвар” болохуйц, өндөр чанартай сургуулийн барилга барихыг зориж байна.

Бусад төсөл.

- 9 сарын 19: Урт хугацааны мэргэжилтэн Гоода (Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв: Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл) буцав.
- 9 сарын 28: Урт хугацааны мэргэжилтэн Накамура (Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв: Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл) ирэв.

Сайн дурын хамтын ажиллагаа

Сайн дурын гишүүний үйл ажиллагаа (Дархан–Уул аймагт өдрийн сувилгаа хийж эхлэв.



Амралт, тэмцээний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн өрхийн эмнэлэг ба сумын эмнэлэгт сайн дурын гишүүн Маада (2015 оны 2 сард томилогдсон/эрүүл ахуйч), сайн дурын гишүүн Савада (2015 оны 2 сар/сэргээн засалч), сайн дурын гишүүн Фужикава (2015 оны 3 сар/сувилагч) нар өдрийн сувилгааны (сэргээн засах дасгал, дахин цус харвахаас сэргийлэх бичил семинар, даралт хэмжих зэрэг) үйл ажиллагаа явуулж эхлэв. Орон нутгийн даралт харвасан өвчтнүүд сэргээн засах эмчилгээ хийлгэх боломж хязгаарлагдмал, гадагшаа гарах, нийгэмтэй харьцах нь бага зэрэг асуудлыг шийдэх үүднээс өдрийн сувилгаа хийж эхэлсэн байна. 9 сарын 3-нд өдрийн сувилгаа, асаргаанд хамрагдсан өвчтнүүд болон тэдний гэр бүлийн оролцоотой амралт, тэмцээний арга хэмжээ зохион байгуулав. Өдрийн сувилгаа болон амралт тэмцээний арга хэмжээг өвчтнүүд болон тэдний гэр бүл өндрөөр үнэлж, сэтгэлж ханамжтай байгаагаа илэрхийлэн, цаашид үргэлжлүүлэн зохион байгуулах хүсэлт тавьж байлаа. Сайн дурын гишүүн Маэкавагийн хугацаа дуусаж 2017 оны 10 сард нутаг буцах боловч сайн дурын гишүүн Фужикава өрхийн эмнэлгүүдээр явж өрхийн эмнэлгүүдийн эмч, сувилагч нартай хамтран өдрийн сувилгааг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

Японы Парламентын Зөвлөхүүдийн танхимын гишүүдтэй санал солилцох уулзалт болов.

9 сарын 16-нд Зөвлөхүүдийн танхимын ХАЁТ-ийн судалгааны баг Монголд айлчилсантай холбогдуулан ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны тэргүүн Ц.Оюунбаатар тэргүүтэй Ерөнхий нарийн бичгийн дарга, удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдсэн нийт 6 хүн, судалгааны багтай оройн зоог барин, санал солилцов. Холбооны тэргүүний зүгээс семинар сургалт (**Follow-up Seminar**) зэрэг холбооны үйл ажиллагааны талаар танилцуулга хийхийн хамт гишүүдийн зүгээс татвар, хууль эрхзүй зэрэг салбарт хэрэгжиж буй Японы хамтын ажиллагааны талаар ярих. Д.Батжаргал удирдах зөвлөлийн гишүүн Монголын байгалийн баялагт нэмүү өртөг шингээгээд экспортлохын тулд ЖДҮ-ийг хөгжүүлэх шаардлагатай байгааг тайлбарлаж, судалгааны багийн зүгээс Японы жишээг танилцуулах зэргээр Монгол улсын байдал, тулгарч буй асуудлын талаар санал солилцон, хоёр талын ойлголтыг гүнзгийрүүлэх боломжийг олгосон уулзалт болов.



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp